

## ӨМНӨХ ҮГ

“Иргэн баян бол улс баян” хэмээх үг буй. Үүний цаана иргэн бүр эрх үүргээ ухамсарлан, өөрийн амьдрал ахуйдаа эзэн болж чадвал улс орны хөгжил сайн сайхан байхыг өгүүлж буй хэрэг билээ. Нөгөө талаас, аливаа улсын хөгжлийн эрхэм зорилго бол ард иргэдийнхээ сайн сайхан аж байдлыг дээшлүүлэх явдал байдаг. Энэ зорилгод хүрэхэд улс орон эдийн засгийн хувьд чадамжтай, хувь хүмүүс санхүүгийн хувьд чадамжтай байх нь илүү чухаг. Төр засаг дангаараа ажиллаад энэ зорилгыг биелүүлэх боломжгүй, гагцхүү үүнд иргэн бүрийн үүрэг, хувь нэмэр, идэвх санаачлага, оролцоо хэрэгтэй юм.

Иймээс Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр 2015 онд батлуулаад байна. Энэхүү хөтөлбөрийн үр дүнд хувь хүн Та өөрийн санхүүгээ зөв удирдан жолоодох, тухайлбал, хувь хүний санхүүгийн талаарх үндсэн


ойлголт, тодорхойлолтууд, орлого, зарлагаа тооцоолох, хянах, хуримтлал, хадгаламжтай болох, хөрөнгө мөнгөө зарцуулахтай холбогдон гарч болох аливаа эрсдэлт байдлаас сэргийлэх, хамгаалах, эдийн засаг, санхүүтэй холбоотой зөв, оновчтой шийдвэр гаргах зэрэг өөрийн өдөр тутмын болоод ирээдүйн эдийн засгийн амьдралд нэн шаардлагатай, мэдвэл зохих хувь хүний санхүүгийн мэдлэг, ур чадварыг эзэмших юм.

Бид хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээгээ хангахыг тэмүүлдэг. Тэгвэл хэрэгцээгээ бүрэн хангахын тулд хязгаарлагдмал нөөц, хөрөнгө мөнгийг зөв зарцуулахтай холбоотой хувь хүний санхүүгийн төлөвлөлт танд маш чухал. Хувь хүн та өөрийн бүхий л талын нөөц бололцоог ашиглах, нийгэм, эдийн засаг, санхүүгийн үйлчилгээний талаарх өөрт хэрэгтэй мэдээлэл олж авах, мэдээлэлдээ тулгуурлан шийдвэр гаргах, сонголт хийхдээ хэрэглэх зөв мэдлэг, хандлага, ур чадвар, зан үйл, дадал зуршлыг энэ гарын авлагаас олж авна гэдэгт бид найдаж байна.

МОНГОЛБАНК  
ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

## ТАЙЛБАР

Сэдвийг амьдралд ойртуулах, ойлгомжтой болгох үүднээс Монголын мянга, мянган өрхийг төлөөлсөн Гарьдын гэр бүлийн гишүүдийн зохиомол дүрийг жишээнд ашиглан айл өрх бүрт тулгардаг санхүүгийн асуудлыг зөв шийдвэрлэхэд туслахыг зорилоо. Та бүхэнд Гарьдын өрхийн гишүүдийг товч танилцуулъя.



# 1. ДААТГАЛ, ТҮҮНИЙ ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ

## Даатгал гэж юу вэ?

Хүний амьдралд учирч болох тааламжгүй үйл явдлын эрсдэлийг бууруулах, учрах хохирлыг хамгийн богино хугацаанд арилгах үр дүнтэй санхүүгийн арга бол даатгал юм. Дэлхийн хүн бүр өөрийн гэсэн өмч хөрөнгөтэй байх энгийн хэрэгцээ байдаг бол түүнийг тааламжгүй үр дагавраас хамгаалах арга болох даатгал хүний өөрийнх нь туулж өнгөрүүлсэн бодит амьдралын хэрэгцээнээс үүсчээ. Хүмүүс хэсэг бүлгээрээ сан бүрдүүлж, тэрхүү сангаасаа хохирол учирсан нэгэндээ туслах болсон нь орчин үеийн даатгалын анхны хэлбэр байсан. Тэрхүү санг үүсгэхэд хамтарч оролцох хүмүүсийн тоо олон байх тусам нэг хүнд ногдох зардлын хэмжээ буурдаг болохыг тогтоосон байна.

Эрсдэл бол хэзээ ч, хэнд ч учирч болно. Зарим хүмүүс өөрийгөө сайн жолооч. Тиймээс ойрын 10 жилд ямар нэгэн осол гаргахгүй явчихна гэж тооцоод даатгалын шимтгэлд төлөх 400,000



төгрөгийг дэмий зүйлд зарцуулж байна гэж бодож болох юм. Гэтэл “Гай газар доороос гахай модон дотроос” гэдэг шиг, эрсдэл хэзээ ч тохиолдож болно. Эрсдэлийг даатгагдах болон үл даатгагдах эрсдэл гэж ангилдаг. Гэнэтийн шинж чанартай, санамсар болгоомжгүй байдлаас үүссэн, хохирол нь мөнгөөр илэрхийлэгдэх боломжтой эрсдэлийг даатгагдах эрсдэл гэдэг. Ийм эрсдэлийг шилжүүлж авдаг бизнес нь даатгал юм.

Даатгуулагч нь эрсдэл учирч болох бүх зүйлийг даатгалын компани буюу даатгагчид даатгуулж болно. Тухайлбал, эд хөрөнгө, хариуцлага, эрүүл мэнд, орлогоо даатгуулж болно. Даатгал нь гэрээний бизнес. Даатгалын компани нь эрсдэл тохиолдох үед нөхөн олговор олгох нөхцөлтэй гэрээг санал болгож харин даатгуулагч нь түүнийг худалдан

авдаг. Энэхүү гэрээг худалдах болон худалдан авах үнэ нь даатгалын хураамж юм. Даатгалын талаар илүү

нарийн ойлголт авахын тулд дараах үндсэн ухагдахууныг ойлгох нь зүйтэй.

### *Хүснэгт 1. Даатгалтай холбоотой үндсэн ухагдахуун*

№	Нэр томъёо	Тодорхойлолт
1.	Даатгал	Ирээдүйд учирч болох аливаа эрсдэлийг шилжүүлэх, багасгахад чиглэсэн үйл ажиллагаа.
2.	Даатгалын зүйл	Даатгалд хамрагдаж байгаа эд хөрөнгө, хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвар.
3.	Даатгалын гэрээ	Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх даатгалын харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичиг.
4.	Даатгалын үнэлгээ	Даатгалын объектыг үнэлж даатгуулсан мөнгөний хэмжээ.
5.	Даатгалын тохиолдол	Даатгуулсан зүйлд эрсдэл тохиолдож, хохирол учрах үйл явц.
6.	Даатгалын хураамж	Даатгалын үнэлгээнээс хамаарч даатгуулагчийн төлж байгаа мөнгөний дүн.
7.	Даатгалын нөхөн төлбөр	Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө.
8.	Даатгалын баталгаа	Даатгалын компанийн зүгээс даатгуулагчдаа даатгасныг баталгаажуулан өгч буй баримт бичиг
9.	Даатгалын хугацаа.	Даатгалын гэрээний хүчинтэй хугацаа.

Даатгуулагч нь даатгалын компанид өөрийн ашиг сонирхлоо даатгуулсны төлөө хураамж төлдөг. Хураамж нь тухайн даатгуулагчийг эрсдэлд

орсон үед хохирлыг нөхөх төлбөр, даатгалын компанийн үйл ажиллагааны зардал, ашгийг багтаасан төлбөр байна. Даатгалын компанийн зүгээс

даатгуулагчид баталгаа гаргаж өгдөг. Энэхүү баталгаанд даатгалын зүйл, эрсдэл, хоёр талын эрх үүрэг, нөхөн төлбөр олгох нөхцөл, үл олгох нөхцөл,

гэрээ цуцлах үндэслэл зэргийг багтаасан байдаг. Даатгалын тохиолдол үүссэн үед нөхөн олговор авдаг.

### Даатгалын харилцаа гэж юу вэ?

Даатгалын харилцаа гэдэг нь даатгалын гэрээтэй холбогдож иргэн болон хуулийн этгээдийн хооронд үүсдэг харилцаа юм. Даатгалын харилцаанд даатгагч, даатгуулагчаас гадна даатгалын мэргэжлийн оролцогч болон зохицуулагч байгууллагууд оролцдог.

Даатгалын мэргэжлийн оролцогч гэдэгт даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгч, даатгалын актуарч зэрэг орох ба Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-оос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлдэг.

### Хүснэгт 2. Даатгалын харилцаанд оролцогчид

№	Оролцогч	Тодорхойлолт	Хамрах хүрээ <sup>1</sup>
1.	Даатгагч	Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага.	Ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1 компани, тэдгээрийн 255 салбар үйл ажиллагаа явуулж байна.
2.	Даатгуулагч	Өөрийн эд хөрөнгө, эрүүл мэнд, ашиг сонирголоо даатгуулж, даатгалын хураамж төлж байгаа хувь хүн, хуулийн этгээд.	Үүнд, Монгол Улсад амьдарч буй бүх иргэд болон үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжүүд орно.
3.	Даатгалын төлөөлөгч	Даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх үүрэг бүхий этгээд.	Нийт 3340 төлөөлөгч даатгалын компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байна.

<sup>1</sup> 2015 оны байдлаар, СЗХ-ны үйл ажиллагааны тайлангаас авав.

№	Оролцогч	Тодорхойлолт	Хамрах хүрээ <sup>1</sup>
4.	Даатгалын зуучлагч	Даатгагчийг даатгуулагчтай холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах эрх бүхий этгээд.	Даатгалын зуучлагчаар нийт 37 компани үйл ажиллагаа явуулж байна.
5.	Даатгалын хохирол үнэлэгч	Даатгалын тохиолдлоор үүссэн бодит хохирлын мөнгөн дүнг хараат бусаар тогтоох үүрэг бүхий этгээд.	Даатгалын хохирол үнэлэгчээр нийт 27 компани үйл ажиллагаа явуулж байна.
6.	Даатгалын актуарч	Даатгагчид учирч болох эрсдэлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээд.	Даатгалын актуарч нийт 15 хүн ажиллаж байна.
7.	Даатгалын зохицуулагч	Даатгалын харилцаа хуулийн дагуу явагдаж буй эсэхийг илрүүлж, хууль сахиулах үүрэг бүхий төрийн байгууллага.	Санхүүгийн зохицуулах хороо

Дээрх этгээдүүдээс гадна даатгалын компанийн санхүүгийн тайланд хараат бус, мэргэжлийн дүгнэлт өгөх үүрэг бүхий аудитын компаниуд СЗХ-оос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулдаг.

Даатгалын үйлчилгээг харилцагчид хүргэдэг 2 төрлийн суваг байдаг бөгөөд эдгээр нь “даатгалын зуучлагч” ба “даатгалын төлөөлөгч” юм. Та даатгуулагчийн хувьд зөвлөгөө авахыг хүсвэл даатгалын зуучлагчид хандана.

Даатгалын зуучлагч нь даатгуулагчид үйлчилж түүнд зөвлөмж, заавар өгөх чиг үүрэгтэй байдаг бол даатгалын төлөөлөгч нь даатгалын байгууллагыг төлөөлөн төв байр нь байгаа газраас өөр газарт үйлчилгээг хүргэдэг.

Даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих замаар даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага нь Санхүүгийн зохицуулах хороо юм. Та

энэ байгууллагын талаар болон бусад нэмэлт мэдээллийг авахыг хүсвэл [www.frc.mn](http://www.frc.mn) хаягаар хандаж болно.

Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг Даатгалын тухай хууль, Иргэний хуулиар зохицуулдаг.

**Хүснэгт 3. Даатгалын харилцааг зохицуулдаг хуулиуд**

№	Хуулийн нэр	Батлагдсан он	Хамрах хүрээ
1.	Даатгалын тухай хууль	2004-04-30	Даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.
2.	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль	2004-04-30	Даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлж, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.
3.	Жолоочийн даатгалын тухай	2011-10-6	Жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.
4.	Иргэний хууль	2002-01-10	Иргэний хуулийн 43-р бүлэгт иргэний зүгээс үүсгэх даатгалын харилцааг нарийвчлан зохицуулсан байна.

## 2. ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ СОНГОХ НЬ

Даатгал нь маш олон төрөлтэй байдаг бөгөөд тэдгээрийг даатгалын харилцааны шинж чанар, хугацаа, зорилго зэргээс хамааруулж ангилдаг. Монгол Улсын “Даатгалын тухай хууль”-д зааснаар даатгалыг урт хугацааны ба ердийн даатгал гэж ангилах бөгөөд албан журмын ба сайн дурын гэсэн хоёр хэлбэртэй<sup>2</sup> байна. Даатгалыг зорилгоос нь хамаарч арилжааны ба нийгмийн даатгал гэж ангилна. Заавал даатгал нь хуулиар зохицуулагддаг бол сайн дурын даатгал нь гэрээний үндсэн дээр хэрэгжинэ.

Хувь хүмүүс өөрсдийн эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвар, амь нас, хариуцлагаа сайн дурын үндсэн дээр даатгуулахын зэрэгцээ зарим төрлийн даатгалд хуульд заасны дагуу заавал даатгуулдаг. Тухайлбал, Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй хөдөлмөрийн гэрээгээр

ажиллаж байгаа хувь хүн нийгмийн даатгалд заавал даатгуулна<sup>3</sup>. Мөн жолоочийн хариуцлагын даатгал нь арилжааны даатгал боловч албан журмын даатгалын төрөлд хамаарна.

Арилжааны даатгалыг амьдралын ба амьдралын бус (ердийн) даатгал гэж ангилна. Амьдралын бус даатгалд хүний өмч хөрөнгө, хариуцлага, амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадвартай холбоотой богино хугацааны даатгалуудыг хамруулж үзэх ба манай улсын даатгалын тухай хуульд ердийн даатгал гэж нэрлэж байна. Хувь хүнтэй холбоотой ердийн даатгалуудад дараах даатгалууд хамаарч байна.

2 Даатгалын тухай хууль. Шинэчилсэн найруулга. (2004). 6.1; 6.2-р дугаар зүйл.

3 Нийгмийн даатгалын тухай хууль. (1994). 4.2.1-р зүйл.



Хүснэгт 4. Даатгалын ангилал

	Даатгалын төрөл	Тодорхойлолт	Жишээ
Объектоор нь	Хувь хүний	Хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварт учрах эрсдлээс хамгаалах зориулалт бүхий даатгал.	Амь насны даатгал, эрүүл мэндийн даатгал гэх мэт
	Эд хөрөнгийн	Хөрөнгөнд өөрийн болон бусдын буруугаас эсвэл давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан учирсан хохирлыг нөхөн төлөх зориулалт бүхий даатгал.	Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн даатгал гэх мэт
	Хариуцлагын	Даатгуулагч этгээдийн зүгээс гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг даатгагчаар нөхөн төлүүлэхээр тохиролцож хийсэн даатгал.	Жолоочийн, эмчийн, өмгөөлөгчийн хариуцлагын даатгал гэх мэт
Хугацаагаар нь	Ердийн даатгал	Нэг хүртэлх жилийн хугацаанд хувь хүний эд хөрөнгө амь нас эрүүл мэндэд учрах эрсдлээс хамгаалах зориулалт бүхий даатгал	Гэнэтийн осол, эмчилгээний, хөрөнгийн, авто тээврийн хэрэгслийн, ачааны, барилга угсралтын, газар тариалангийн, мал амьтдын даатгал гэх мэт
	Урт хугацааны даатгал	Нэгээс дээш жилийн хугацаанд хувь хүний амьдралд учирч болох эрсдлээс хамгаалах зориулалт бүхий даатгал	Хугацаат амьдралын, насан туршийн, хуримтлалын, тэтгэврийн, эрүүл мэндийн гэх мэт

	Даатгалын төрөл	Тодорхойлолт	Жишээ
Төрлөөр нь	Заавал	Хуульд заасны дагуу заавал даатгуулах даатгал.	Жолоочийн хариуцлагын даатгал, нийгмийн даатгал гэх мэт
	Сайн дурын	Иргэн, хуулийн этгээдүүд өөрийн хүсэлтийн үндсэн дээр даатгуулж болох даатгал.	Тээврийн хэрэгслийн гэх мэт
Зорилгоор нь	Нийгмийн даатгал.	Төрөөс хэрэгжүүлж буй ашгийн төлөө бус даатгал.	Тэтгэврийн, эрүүл мэндийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн гэх мэт.
	Арилжааны даатгал.	Хувийн даатгалын компаниудын хэрэгжүүлдэг ашгийн төлөөх даатгал.	Эд хөрөнгийн, тээврийн хэрэгслийн, орон сууцны гэх мэт.

Жишээлбэл: Гарьд авто машин жолоодож замын хөдөлгөөнд оролцох үедээ санамсаргүй бусдын авто машиныг мөргөж гэмтээх тохиолдолд гуравдагч этгээдэд учруулсан хохирлоо жолоочийн хариуцлагын даатгалын сангаас нөхөн төлүүлж болно. Харин тээврийн хэрэгслийн даатгалд даатгуулсан бол өөрийн авто машинд

учирсан хохирлыг барагдуулж болох юм. Эндээс машин барьж авто замын хөдөлгөөнд оролцдог л бол жолоочийн хариуцлагын даатгалд заавал даатгуулах учиртай, харин тээврийн хэрэгслээ заавал даатгуулах албагүй бөгөөд энэ нь сайн дурын даатгал болох юм.

Хүснэгт 5. Даатгалын хэлбэр, тодорхойлолт

№	Даатгалын төрөл	Агуулга
1.	Эд хөрөнгийн даатгал	Хувь хүн, байгууллагын өмчлөлд хамаарах бүх төрлийн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн даатгал.
2.	Гэнэтийн ослын даатгал	Даатгуулагч гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн болон хэсэгчлэн алдах, нас барсан тохиолдолд даатгуулагчид эсвэл түүний ар гэрийнхэнд нөхөн олговор олгох агуулга бүхий даатгал.
3.	Эрүүл мэндийн даатгал	Иргэн ба хуулийн этгээдийн төлсөн даатгалын хураамжаар даатгалын санг бүрдүүлсний үндсэн дээр даатгуулагчдын эмчилгээ үйлчилгээний зардлыг төлөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ.
4.	Иргэдийн хариуцлагын даатгал	Даатгуулагчаас гуравдагч этгээдэд ам нас, эд хөрөнгө, эрүүл мэндэд учруулсан хохирлыг нөхөн төлөх агуулга бүхий даатгал.
5.	Жолоочийн хариуцлагын даатгал	Тээврийн хэрэгслийн жолоочийн санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учруулах хохирлыг нөхөн төлөх агуулга бүхий даатгал.
6.	Орон сууц эзэмшигчийн хариуцлагын даатгал	Орон сууц эзэмшигчийн болон өмчлөгчийн буруутай вйл ажиллагаанаас шалтгаалж гарах сууц дундын өмчлөлийн эд хөрөнгө, сууц эзэмшигчдийн болон бусдын эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд учирч болох эрсдэлээс хамгаалах даатгал.

Даатгалын компаниудын санал болгодог олон төрлийн даатгалаас хэрхэн сонголт хийх талаарх зөвлөгөөг дараах зургаас харж болно. Ингээд эцэст нь танд зөвлөхөд танд хэрэггүй

даатгалд бүү хамрагдаарай. Их хэмжээний хохиролд өртөх зүйлүүдээ эхний ээлжинд даатгуулах нь танд ашигтай.

*Зураг 1. Даатгалын бүтээгдэхүүн авахад анхаарах зүйлс*



### 3. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙГ ХЭРХЭН ЯАЖ АВАХ ВЭ?

Хэрэв даатгалын гэрээний хүчинтэй хугацаанд даатгалын тохиолдол гарсан бол хохирлыг нөхөх үүргийг даатгагч хүлээдэг. Даатгалын төрөл, хэлбэрээс хамаарч даатгалын тохиолдол янз бүр байх ба үүнээс хамаарч даатгуулагчийн зүгээс авах арга хэмжээ ч өөр байна. Тухайлбал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тохиолдлын үед та:

- ▶ Замын цагдаагийн газар дуудлага өгөх;
- ▶ Ослын улмаас хүн бэртэж, гэмтсэн бол түргэн тусламж дуудах;
- ▶ Даатгалын компанийн шуурхай албанд дуудлага өгөх;
- ▶ Хэрэв дуудлага өгөх боломжгүй бол ослын газрын зургийг дөрвөн талаас, орчин нөхцөлийг оролцуулан, эвдрэлийг тодруулан авах;
- ▶ Осол гарсны улмаас зам түгжирсэн тохиолдолд ослын газрын зургийг авсны дараа байрнаас хөдөлгөх зэрэг арга хэмжээг авна.

Даатгуулагч даатгалын хохирлыг нөхөн төлүүлэхийн тулд даатгагчийн шаардсан баримтыг бүрүүлнэ. Даатгуулагчийн бүрдүүлэх баримт нь даатгалын төрлөөс хамаарч өөр өөр байх боловч дараах нийтлэг баримтууд шаардлагатай байдаг. Үүнд:

- ▶ Даатгалын гэрээний эх хувь;
- ▶ Даатгуулагчийн өргөдөл;
- ▶ Хохирол гарсан шалтгаан, хохирлын зүйлийг тогтоосон акт материал;
- ▶ Мэргэжлийн холбогдох байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт (засварын газрын дүгнэлт, эмчийн магадлагаа гэх мэт) ;
- ▶ Эрх бүхий байгууллагын хүлээн зөвшөөрсөн үнэлгээний компанийн гаргасан хохирлын үнэлгээний тайлан;
- ▶ Хохирлын нөхцөл байдал, орчинг харуулсан фото зураг гэх мэт.



---

Даатгалын нөхөн төлбөр хийгдэхгүй байж болох дараах нөхцөлүүд бий. Үүнд:

---

- ▶ Даатгалын тохиолдлыг санаатайгаар бүрдүүлсэн;
- ▶ Дайн байлдаан, хувьсгал, төрийн эргэлт, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, бослого, үймээний улмаас даатгалын тохиолдол болсон;
- ▶ Эвдэрч гэмтсэний дараа даатгуулсан;
- ▶ Буруутай этгээдээр хохирлоо нөхүүлсэн;
- ▶ Даатгалын хураамж төлөөгүй;
- ▶ Даатгалын төлбөр хийлгэх хугацаанд хандаагүй;
- ▶ Аж ахуйн нэгжийн ажилтны болон дээд байгууллага, харилцагчийн хариуцлагагүй үйл ажиллагаа, техник технологи, хадгалалт, тээвэрлэлтийн горим зөрчсөнөөс даатгалын тохиолдол болсон;
- ▶ Даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн

## 4. АМЬДРАЛЫН ДААТГАЛ

Амьдралын даатгал нь хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл тохиолдсон үед даатгуулагчийнхаа орлогыг тасалдалгүй үргэлжлүүлэх, улмаар тэдний гэр бүлийн санхүүгийн тогтвортой байдлыг баталгаажуулах үүрэгтэй байдаг. Мөн хувь хүн болоод нийгмийн өмнөө тавьсан зорилгод хүрэхэд шаардлагатай мөнгөн хуримтлалыг бий болгох хөрөнгө оруулалтын хэрэгсэл болдог юм. Амьдралын даатгал нь ердийн даатгалтай харьцуулахад дараах онцлог ялгаатай байдаг. Үүнд:

1. Урт хугацаатай;
2. Даатгалын объект нь зөвхөн хүний амь нас, эрүүл мэнд, амьдрах баталгаат байдалтай холбоотой зүйл болдог ба үүнд: нэмэлт тэтгэвэр, тэтгэврийн даатгалын өв залгамжлал, эрүүл мэндийн даатгалын онцгой төрлүүд, хуримтлал зэргийг ойлгоно.
3. Ирээдүйд тохиолдох тодорхой эрсдэлийг /нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалт г.м./ даатгадаг.

Амьдралын даатгалын эрсдэл нь хүний амьдрах хугацаа болдог бөгөөд нас баралтын, насжилтын, эрүүл мэндийн гурван төрөлтэй байна. Үүнтэй холбоотойгоор амьдралын даатгалыг амь насны, хуримтлалын, тэтгэврийн, эрүүл мэндийн гэсэн төрлүүдэд хуваадаг.

Амьдралын даатгалд хамрагдсанаар:

- ▶ Өөрийгөө болон гэр бүлийнхээ өнөөдрийг төдийгүй ирээдүйг хамгаалах;
- ▶ Өөртөө болон гэр бүлдээ санхүүгийн хөрөнгө оруулалт хийх;
- ▶ Хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулан өндөр өгөөж хүртэх;
- ▶ Ирээдүйн эрсдэлд хамгаалалттай, санхүүгийн хувьд бэлтгэлтэй байх;
- ▶ Ирээдүйдээ итгэлтэй, сэтгэл хангалуун амьдрах суурийг тавих;
- ▶ Эрүүл мэнддээ шаардагдах хөрөнгийн баталгааг бий болгох зэрэг боломж бүрдэнэ.

Иймээс амьдралын даатгалын төлөвлөлтийг хийхдээ өөрийн санхүүгийн зорилго, даатгалын хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх нь зүйтэй. Үүний тулд:

1. Ар гэрийнхэндээ хичнээн мөнгө үлдээхийг хүсч байна вэ?
2. Хэзээ тэтгэвэрт гарах вэ? Тэтгэвэрт гарсны дараа хичнээн хэмжээний нэмэлт орлого шаардлагатай болох вэ?
3. Даатгалын хураамжид хичнээн хэмжээний мөнгө төлж чадах вэ? гэдэг асуултад хариулах шаардлагатай болно. Энэ нь амьдралын даатгалын төрлүүдээс сонголт хийхэд тусална.

Амьдралын даатгал нь урт хугацаанд зөвхөн хүний амь нас, эрүүл мэнд, амьдралтай холбогдсон даатгалуудыг хийдгээрээ, ирээдүйд тохиолдох тодорхой эрсдэлийг даатгадгаараа ердийн даатгалаас ялгаатай.